



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр


Дугаар А/525

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар анги үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахмад зүтгэлтнүүд болох Т.Сэржмядаг Б.Балжинням, Я.Одсүрэн, Ё.Цэвээнжав, Ц.Дорж, Г.Оюунцэцэг, Ж.Цэцэгмаа, Д.Тунгалаг, Ч.Энхээ, М.Лхагвасүрэн нарыг аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнаход 300,000 төгрөг (гурван зуун мянга)-ийг зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 300,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

Zah A/525 Bo
8400 01 2639